



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/35


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 33 дугаар зүйлийн 33.1.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 3 дугаар хэсгийн 3.1.3, 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийг арчлах, мод, сөөг, зүлэг, цэцэг тарих ажлыг гүйцэтгэх мэргэжлийн цэцэрлэгчдийг сургаж бэлтгэх ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв /МСҮТ/-ийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Цэцэрлэгчдийг сургаж бэлтгэх Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 04 сарын 14  
өдрийн 11:51 тушаалын хавсралт



ЦЭЦЭРЛЭГЧИН БЭЛТГЭХ СУРГАЛТ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга :	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Улаанбаатар хот. Сүхбаатар дүүргийн 3-р хороо. 24-р байр. 39 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн дарга:	бичгийн Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн